

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/08-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 70362442 Цахим хаяг: tsogtj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10-16
4. Аудитын тайлан.....	16-19
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16-17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18-19
5. Аудитын илрүүлэлт	19-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил , үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.22 № ЦАА-2024/08-НА-САА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үйл ажиллагаанд 1,719,685.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 93.3 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 6.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ЗДТГ нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг буюу өөрийн үйл ажиллагааны орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт багаар буюу 500.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 11,960.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	615,912.5	461,387.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	404,873.4	215,220.4
33	АВЛАГА	177,370.5	211,295.5
35	БАРАА МАТЕРИАЛ	33,668.6	34,871.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,959,416.0	2,755,301.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,959,416.0	2,755,301.1
39200	Биет хөрөнгө	1,929,970.6	2,731,304.2
39300	Биет бус хөрөнгө	29,445.4	23,996.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,575,328.4	3,216,688.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,650.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,650.9
41300	Өглөг	-	2,650.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,575,328.4	3,214,037.9
51	Засгийн газрын хувь оролцоо	2,575,328.4	3,214,037.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	262,048.7	262,048.7
51200	Хуримтлагдсан үр дүн	2,187,651.6	2,826,361.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,628.1	125,628.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,575,328.4	3,216,688.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,087,473.0	2,509,397.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	341,459.9	509,575.1
110	Орлогын албан татвар	130,089.7	265,239.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	130,089.7	283,378.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(18,139.2)
113	Хөрөнгийн албан татвар	106,410.1	161,734.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	104,960.1	82,601.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	159,100.3	1,264,907.1
120	Нийтлэг татварын бус орлого	159,100.3	975,873.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	289,033.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,586,912.8	734,914.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,573,831.9	1,354,971.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,573,831.9	1,323,497.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,077,020.0	1,299,353.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,008.3	415,314.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,831.6	53,831.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,567.1	35,280.6
2104	Хангамж, бараа материалын зардал	48,520.1	42,464.8
2105	Нормативт зардал	-	274.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,036.9	9,623.9
2107	Томиллолт, зочны зардал	3,157.6	5,705.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,791.8	392,252.1

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,106.6	344,606.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,496,811.9	24,144.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	31,474.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	513,641.1	1,154,425.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,661,668.6	512,715.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,148,027.6)	641,709.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,685,528.0	-	5,685,528.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,575,328.4	-	2,575,328.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,723,356.0	-	5,723,356.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	37,828.0	-	37,828.0
9	Тайлант үеийн үр дүн	(3,148,027.6)	-	(3,148,027.6)
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,575,328.4	-	2,575,328.4
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,214,037.9	-	3,214,037.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,572,328.4	-	2,572,328.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,000.0)	-	(3,000.0)
19	Тайлант үеийн үр дүн	641,709.4	-	641,709.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,099,814.4	1,716,655.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	341,459.9	509,575.1
110	Орлогын албан татвар	130,089.7	265,239.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	130,089.7	283,378.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(18,139.2)
113	Хөрөнгийн албан татвар	106,410.1	161,734.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	104,960.1	82,601.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,381.6	8,775.7
1181	Газрын төлбөр	71,922.8	41,405.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,655.8	32,420.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,401.6	472,174.2
120	Нийтлэг татварын бус орлого	162,401.6	183,141.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	289,033.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,595,952.9	734,905.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,415,296.6	1,052,689.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,415,296.6	1,052,689.2

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	907,193.0	1,028,545.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,897.8	415,087.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,168.1	54,049.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	400,941.6	35,280.6
2104	Хангамж, бараа материалын зардал	37,947.1	41,261.9
2105	Нормативт зардал	411.3	274.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,621.6	9,623.9
2107	Томилолт, зочны зардал	3,157.6	5,705.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,985.0	393,358.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,062.9	73,903.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,508,103.6	24,144.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	684,517.8	663,965.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	826,795.1	732,618.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	826,795.1	732,618.7
2200	Дотоод эх үүсвэрээр	826,795.1	732,618.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(826,795.1)	(732,618.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(115,000.0)	(121,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	115,000.0	121,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(257,277.4)	(189,653.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	662,150.8	404,873.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	404,873.4	215,220.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,955,758.9	1,824,976.2	(130,782.7)	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,517.7	102,832.0	(990,685.7)	9.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,067,783.8	987,744.4	(80,039.4)	92.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,345.2	414,837.7	(34,507.5)	92.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,911.2	54,049.6	(2,861.6)	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,029.4	384,329.9	(24,699.5)	94.0
2104	Хангамж, бараа материалын зардал	42,341.2	39,025.3	(3,315.9)	92.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	359.6	274.0	(85.6)	76.2
2107	Томилолт, зочны зардал	44,507.3	43,024.7	(1,482.6)	96.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,638.7	5,705.0	(1,933.7)	74.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,504.0	10,908.6	(7,595.4)	59.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,733.9	15,087.6	(10,646.3)	58.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,733.9	15,087.6	(10,646.3)	58.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	732,241.2	701,144.2	(31,097.0)	95.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	130,000.0	121,000.0	(9,000.0)	93.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,955,758.9	1,719,685.0	(236,073.9)	87.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,416,735.9	1,635,599.1	218,863.2	115.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	539,023.0	84,085.8	(454,937.2)	15.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	154,656.4	154,656.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	55,078.9	55,078.9	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,776.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,302.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,800.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,236.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,314.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,501.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	680.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,821.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,474.6
2200	Дотоод эх үүсвэрээр	31,474.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,776.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,776.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хамтын зүтгэлээр Орхон нутгаа хөгжүүлэе” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, ирээд олон нийтэд мэдээлэх,*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,*
- *Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,*
- *Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,*
- *Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,*
- *Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэх.*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ТБОНӨХБАҮХАТ хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхон сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 641,360.4 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	404,873.4	215,220.4	(189,653.0)
Авлага	177,370.5	211,295.5	33,925.0

Бараа материал	33,668.6	34,871.7	1,203.1
Үндсэн хөрөнгө	1,959,416.0	2,755,301.1	795,885.1
Нийт хөрөнгө	2,575,328.4	3,216,688.8	641,360.4
Өр төлбөр	-	2,650.9	2,650.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,575,328.4	3,214,037.9	638,709.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,575,328.4	3,216,688.8	641,360.4

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 404,873.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 215,220.5 мянган төгрөг болж, 189,653.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	404,873.4	215,220.4	(189,653.0)
Төрийн сангийн харилцах	404,873.4	215,220.4	(189,653.0)
Дүн	404,873.4	215,220.4	(189,653.0)

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд ОНЕО-ын дансны 160,141.5 мянган төгрөгийн, ХХС-ийн дансны 55,078.9 мянган төгрөгийг үлдэгдэл тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 177,370.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 211,370.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,925.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	5,404.4	6,591.1	1,186.7
Зээлийн авлага	171,966.1	204,779.4	32,813.3
Дүн	177,370.5	211,370.5	33,925.0

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ХХС-ийн зээлийн 204,779.4 мянган төгрөгийн, хүүгийн 6,591.1 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 33,668.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 34,871.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,203.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	-	287.0	287.0
Тусгай зориулалттай материал	-	287.0	287.0
Хангамжийн материал	33,668.6	34,584.7	916.1
Бичиг хэргийн материал	1,103.5	1,008.1	(95.4)
Аж ахуйн материал	14,781.8	14,795.3	13.5
Барилгын материал	-	41.0	41.0
Түлш, шатах тослох материал	159.0	159.0	-
Хүнсний материал	1,166.7	1,166.7	-
Бусад хангамжийн материал	16,457.6	17,414.6	957.0
Дүн	33,668.6	34,871.7	1,203.1

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орхон сумын ТТЗ-ийн дүнгээр нийт 73,209.5 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 76,006.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,959,416.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,755,301.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 795,885.14 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	989,983.3	1,771,679.4	781,696.1
Хуримтлагдсан элэгдэл	(151,809.1)	(191,600.8)	(39,791.7)
Авто-тээврийн хэрэгсэл	239,707.1	239,707.1	-
Хуримтлагдсан элэгдэл	(69,930.3)	(106,100.3)	(36,170.0)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	128,564.7	178,564.7	50,000.0
Хуримтлагдсан элэгдэл	(50,970.4)	(72,643.4)	(21,673.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	52,817.4	54,010.2	1,192.8
Хуримтлагдсан элэгдэл	(23,902.8)	(32,071.0)	(8,168.2)
Зам, гүүрийн байгууламж	578,283.5	578,283.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(243,017.4)	(308,151.4)	(65,133.9)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,000.0	14,000.0	-
Бусад үндсэн хөрөнгө	601,707.1	834,054.5	232,347.4
Хуримтлагдсан элэгдэл	(135,662.6)	(228,628.3)	(92,965.6)
Ном	200.0	200.0	-
Биет бус хөрөнгө	29,445.4	23,996.9	(5,448.5)
Програм хангамж	3,950.0	3,950.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,696.9)	(2,809.4)	(1,112.5)
Бусад биет бус хөрөнгө	27,192.3	27,192.3	-
Хуримтлагдсан элэгдэл	-	(4,336.0)	(4,336.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,959,416.0	2,755,301.1	795,885.1

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 795,885.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 158,428.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ОНХС-аас 450,854.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, бусад хөрөнгө 172,413.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг авсан.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр нь 2,650.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг		326.9	326.9
Байгууллагад төлөх өглөг		1,295.2	1,295.2
Дүн		1,622.1	1,622.1

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь ЗДТГ-ын жилийн эцсийн гүйлгээг хийсэн боловч Тамгын газрын дарга батлалгүйгээр хугацаа хоцроосноос шалтгаалан өр төлбөр үүссэн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,575,328.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,214,037.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 638,709.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,575,328.4	3,214,037.9	638,709.5
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	262,048.7	262,048.7	
Хуримтлагдсан үр дүн	2,187,651.5	2,826,361.0	638,709.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,628.1	125,628.1	
Дүн	2,575,328.4	3,214,037.9	638,709.5

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 638,709.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2023 оны орон нутгийн төсөв батлах тухай 2023 оны 61 дүгээр тогтоолоор тайлант онд 386,560.0 мянган төгрөгийн татварын орлого, 36,782.5 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр

батлагдсанаас гүйцэтгэлээр 509,575.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 20.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

	/мянган төгрөг/			
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	131,539.2	143,114.9	11,575.7	108.8
Үйл ажиллагааны орлого	16,100.0	132,967.3	116,867.3	825.9
Хөрөнгийн орлого	8,300.0	7,296.2	(1,003.8)	87.9
Хөрөнгө борлуулсны орлого	5,100.0		(5,100.0)	0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,200.0	4,111.0	(89.0)	97.9
Бууны албан татвар	950.0	2,106.0	1,156.0	221.7
Малд ногдуулах албан татвар	156,943.0	155,517.3	(1,425.7)	99.1
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	6,519.4	519.4	108.7
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	451.0	2,256.3	1,805.3	500.3
Газрын дуудлага худалдаа	9,600.0	13,979.4	4,379.4	145.6
Газрын төлбөр	57,446.0	27,426.2	(30,019.8)	47.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0		(2,000.0)	-
Агнуурын нөөц ашигласны төлбөр	90.0	110.0	20.0	122.2
Байгалийн ургамал ашигласны төлбөр	5,980.0	32,310.3	26,330.3	540.3
Бусад орлого	19,782.5	29,183.4	9,400.9	147.5
Торгуулийн орлого	16,500.0	64,158.0	47,658.0	388.8
Нийт дүн	423,342.5	509,575.1	86,232.6	120.4

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь:

- цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого 11,575.7 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 116,867.3 мянган төгрөгөөр,
- Газрын дуудлага худалдааны орлого 4,379.4 мянган төгрөгөөр,
- Галт зэвсгийн татвар 1,156.0 мянган төгрөгөөр,
- Байгалийн ургамал ашигласны төлбөр 26,330.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж 519.4 мянган төгрөгөөр,
- Түгээмэл тархац 1,805.3 мянган төгрөгөөр,
- Бусад орлого 9,400.9 мянган төгрөгөөр,
- Торгуулийн орлого 47,658.0 мянган төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөгөө тасарсан орлого:

- Хөрөнгийн орлого 1,003.8 төгрөгөөр,
- Хөрөнгө борлуулсны орлого 5,100.0 мянган төгрөгөөр,
- Малын тоо толгойн татвар 1,425.7 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөр 30,019.8 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын төлбөр 2,000.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 1,728,546.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 47 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 406,560.0 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 657,119.0 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 239,535.6 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 130,000.0 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 404,623.08 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 500.0 мянган төгрөг зэрэг нийт **1,841,757.5** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 61 дүгээр тогтоолоор төсвийн орлогыг 423,342.5 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 704,860.2 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 289,033.2 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 133,900.0 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 404,623.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 500.0 мянган төгрөг зэрэг нийт **1,956,259.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 606,167.5 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 289,033.2 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 404,623.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 133,900.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 509,575.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 12,460.0 мянган төгрөг нийт **1,955,758.9** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,824,976.2** мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв болон тусгай шилжүүлгийн байгууллагуудад олгох тогтмол зардлын санхүүжилтийг хэмнэснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс сургуулийн дээвэр засварын ажилд 32,474.5 мянган төгрөгийн, аймгийн Статистикийн хэлтсээс 1,581.3 мянган төгрөгийн, аймгийн ГБХЗХГ-аас 2,800.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болгосон орлого 11,960.0, туслах үйл ажиллагааны орлого 32,960.8 мянган төгрөг зэрэг нийт 81,776.6 мянган төгрөгийн нэмэлт орлогыг тус тус бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 250.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 2,236.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 38,314.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 9,501.3 мянган төгрөг зэрэг нийт 50,302.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 31,474.5 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Орхон сумын ОНХО-ын хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 159,602.6 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 386,198.0 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зэрэг нийт 14 удаагийн цахим тендерийн урилгыг tender.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, хөтлөх, ЖМС-ийн тайланг батлагдсан маягтын дагуу үнэн зөв хөтөлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ТТЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тус ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,087,473.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 30,874.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Батлагдсан төсвийг 6.7 хувиар хэмнэсэн,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй, сонин хэвлэл захиалаагүй,
- Үндэсний баяр наадмаас бусад баяр ёслол, ойн арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,
- Хоршоог хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн 12 зээлдэгчийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласны үр дүнд 18,616.1 мянган төгрөгийн чанаргүй зээлийг төлүүлсэн,
- Тус ТТЗ-ийн харьяаны байгууллагуудын эзэмшлийн 1 авто машинд тусгай дугаар авсан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	168	156	12	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	171		
3	Засаг даргын Тамгын газар	171	162	9	
	Нийт дүн	510	489	21	

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

ТТЗ болон харьяа байгууллагууд нь мэдээлбэл зохих 489 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 21 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 24,023.7 мянган төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 2,549.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 14,804.4 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 6,670.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 89.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,549.3	1	2,549.3	100.0
Албан шаардлага	4	14,804.4	3	12,261.6	67.0
Зөвлөмж	2	6,670.0	2	6,670.0	100.0
Нийт дүн	7	24,023.7	6	21,480.9	85.7

Өмнөх аудитаар өгөгдсөн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Алтаншагайд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл,

арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг аудитад хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **38,670.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **20,814.0** мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, **17,856.0** мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Дэнж хороололд гүний худаг гаргах” төсөл арга хэмжээний явцын гүйцэтгэлийг үнэлсэн хуудас, мэдээ, тайлангүйгээр **15,000.0** мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”-ын 4.1.12 дахь “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ИТХ:

2. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын батлагдсан төсвөөс сумын нас барсан иргэдийн ар гэрт буцалтгүй тусламж болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах уралдаан, тэмцээн, арга хэмжээний шагналд **1,130.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

3. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,650.9** мянган төгрөгийн бичиг хэрэг болон цахилгааны өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Бараа, ажил үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд **2,033.1** мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Бараа, үйлчилгээний бусад зардал: Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа, үйлчилгээнд төлөх зардлыг буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль, тогтоомж, эрх зүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил, үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд энд хамаарна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зэрэг үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөлгүйгээр нийт **15,256.0** мянган төгрөгийн /ЗДТГ-13,053.0 мянган төгрөг, ИТХ-2,203.0 мянган төгрөг/ шатахуун зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил,

гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар*”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

2. ЖМС-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь ЖМС-ийн **2,600.0** мянган төгрөгийн зарцуулалтын тайланг журмын дагуу бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “*Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам*”-ын 2.7 дахь заалт болон маягт 1-тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон сумын ТТЗ	7	38,670.0			4	20,814.0	2	17,856.0	1	-		
Дүн	7	38,670.0			4	20,814.0	2	17,856.0	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Нийт 21 мэдээллийг хугацаа хоцроосон	1								1	
Нийт дүн	1								1	